



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/С

Төмөрбулаг сум

Мод бэлтгэх эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7, сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 09 тоот тогтоолыг-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2022 оны ойн аж ахуйн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж үнэлүүлсэн ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудад сумын 2021-2024 хүртэл хэрэгжүүлэх ойн менежментийн төлөвлөгөө болон сумын ИТХ-ын 2022 оны тогтоол ёсоор мод бэлтгэх баг, Мөрөн сум, мэргэжлийн байгууллагад хэрэглээний модыг 1520 м/куб-ээр, 12534 м/куб-ээр нийт 14054 м/куб-ээр зөвшөөрөл олгосугай.

2. Батлагдсан дээд хязгаарт багтаан арчилгаа, цэвэрлэгээний огтлолт явуулах цэвэрлэгээний ажил хийх, ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд бэлтгэх мод бэлтгэх талбай тусгаарлалтыг харъяалсан "Эрчимт-Идэр" сум дундын ойн ангиар хийлгэхийг БОТХБТасгийн дарга /Ч.Энхбаяр/-т даалгасугай.

3. Тухайн жилийн ойн менежментийн төлөвлөгөөний батлагдсан хэмжээнээс илүү мод бэлтгүүлэхгүй хяналт шалгалтын ажлыг сайтар зохион байгуулан ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн /Д.Хишигсайхан/ Байгаль хамгаалагч /Ч.Амаржаргал, М.Оюунчимэг / нарт үүрэг болгосугай.

4. Аж ахуйн нэгж байгууллагын ойжуулалтын ажлыг зохион байгуулах, хүлээн авах ажлын хэсэг байгуулах, үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнахыг БОТХБТын дарга /Ч.Энхбаяр/-т үүрэг болгосугай

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга /Г.Нямханд / нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БЯМБАСҮРЭН